# ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# “ОРХОН АЙМГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ” АУДИТЫН ТАЙЛАН



**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРИМ ОРЛОГО ТАСАРЧ, КОВИДТОЙ ХОЛБООТОЙГООР ЗАРДЛЫН ХЭМНЭЛТ ҮҮСЧ, ХО-ЫН АЖЛУУД ХОЙШЛОГДОН ОН ДАМЖИН ХЭРЭГЖИХЭЭР БОЛЖЭЭ.**

**Орхон аймаг**
**2021 он**

**Аудитын тайланг бэлтгэсэн:**

**Орхон аймаг дахь Төрийн аудитын газар:**

Дарга, Тэргүүлэх аудитор:
Ц.Нармандах

Аудитын менежер:
Б.Эрдэнэ
Аудитор:
Т.Болормаа
О.Гантуяа

**2021 оны 04 дүгээр сар**

Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.

Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү.
/www.audit.mn/

**Хаяг:**
Орхон аймаг дахь Төрийн аудитын газар
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон

Орхон аймаг

**АГУУЛГА**

Товчилсон үгийн жагсаалт....................................................................... 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл: 3

**БҮЛЭГ 1. Жаргалант сумын өмнөх оны ерөнхий орлогын дансны үлдэгдлийг энэ онд ОНХС-ийн эх үүсвэр талд баталсан нь Төсвийн тухай хуулийг, Эрдэнэт сангийн төсөвт ОНӨҮГ-ын төсөв батлагдаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.** 5 5

1.1 Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 8,650.2 сая төгрөг, зарлагыг 3,157.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.

**1.**2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Эрдэнэт сангийн төсөв батлахдаа ОНӨҮГ-т санхүүжилт олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зүйл заалттай нийцэхгүй байна. 7

1.3 Жаргалант сумын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг энэ онд санхүүжихээр эх үүсвэр талд баталсан нь Төсвийн тухай хуулийн 60.2 дахь хэсгийг зөрчсөн байна. 9

**БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн зарим орлого тасарсан боловч цар тахалтай холбоотойгоор хэмнэлт үүссэн, боловсролын байгууллагууд төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан байна.** 10

2.1 Газрын төлбөрийн орлого 2,710.0 сая төгрөг, хог хаягдлын хураамж 22.8 сая төгрөгөөр тасарсан байна. 11

2.2 Төсвийн зардлын хэмнэлт нь ковид 19 цар тахалтай холбоотойгоор Сангийн яамнаас зарим зардалд хязгаарлалт хийснээс шалтгаалж төсвийн гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна. 12

2.3 Тусгай шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг бодитой төлөвлөөөгүйгээс 281.2 сая төгрөгийн хэмнэлт үүсч, цалингийн зардлын хэмнэлтээс 339.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 16

2.3.1 Сургуулийн өмнөх боловсролын салбарын тогтмол зардлыг орон нутгаас олгохдоо бодитой төлөвлөөгүйгээс 180.12 сая төгрөгийн хэмнэлт үүссэн, цалингийн хэмнэлтээс урамшуулалд 96.2 сая төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. 16

2.3.2 ЕБС-ийн салбарын тогтмол зардлыг орон нутгаас олгохдоо бодитой төлөвлөөгүйгээс 101.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн, цалингийн хэмнэлтээс урамшуулалд 243.5 сая төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. 20

**БҮЛЭГ 3. Ковид цар тахлаас шалтгаалан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 35 төсөл арга хэмжээ бүрэн дуусаагүй он дамжин хэрэгжиж байна.** 24

3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.8 хувийн биелэлттэй байна. 24

3.2 2020 онд ОНХС-аас олгох аймаг, сумын орлогын шилжүүлгийг 4,744.2 сая төгрөгөөр баталсан байна. 25

3.3 2019 онтой харьцуулахад нэмэлт төсвийн гүйцэтгэлийн зардал 1,337.0 сая төгрөгөөр өссөн байна. 26

**Дүгнэлт** 29

**Зөвлөмж** 30

**Тэргүүлэх аудиторын тушаал**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| УИХ | Улсын Их Хурал |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| АИТХ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| ҮХЭХ | Үл хөдлөх эд хөрөнгө |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| АТБӨЯХАТ | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| ТТАМ | Түгээмэл тархацтай ашигт малтмал |
| ОАТ | Орлогын албан татвар |
| ААН | Аж ахуй нэгж |
| ГБХЗХГ | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ХББЗА | Хот байгуулалт, барилга захиалагчийн алба |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| СХАА | Санхүүгийн хяналт, аудитын алба |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ЗД | Засаг дарга |

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Орхон аймаг дахь төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 2.4 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт:**

Орхон аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит гүйцэтгэнэ. Үүнд:

- 2020 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл,
- 2020 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- 2020 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл түүний танилцуулга

**Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг аймгийн ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулլаа.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол

**Аудит хийх бүрэлдэхүүн:**

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдан, менежер Б.Эрдэнэ чанарын хяналт хийж, аудитор Т.Болормаа, О.Гантуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

**Үндсэн мэдээлэл:**

Орхон аймгийн 2020 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, Засаг даргын нөөц сан, Орон нутгийн хөгжлийн сан, Нийгмийн халамжийн сан, орон нутагт хэрэгжүүлж байгаа Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Эрдэнэт сан, орон нутгийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлэгтэй ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нийт аймгийн хэмжээгээр 98 байгууллага санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн 2020 оны орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,295.9 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 29,220.1 сая төгрөгөөр баталжээ.

Орхон аймгийн 2020 оны орлого зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2019 оны 11 сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор 131,593.2 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Үүнээс: татварын орлогыг 66,368.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 758.2 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 49,142.2 сая төгрөгөөр, урьд оны шилжих үлдэгдлийг 15,324.9 сая төгрөгөөр баталсан.

**БҮЛЭГ 1. Жаргалант сумын өмнөх оны ерөнхий орлогын дансны үлдэгдлийг энэ онд ОНХС-ийн эх үүсвэр талд баталсан нь Төсвийн тухай хуулийг, Эрдэнэт сангийн төсөвт ОНӨҮГ-ын төсөв батлагдаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.**

**1.1 Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 8,650.2 сая төгрөг, зарлагыг 3,157.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.**

Аймгийн төсвийн орлогын хяналтын хуудсыг батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд:

| Үзүүлэлт /сая төгрөг/ | Суурь орлого /Санал/ | Суурь орлого /Хянасан/ | Зөрүү | Нийт орлого /Санал/ | Нийт орлого /Хянасан/ | Зөрүү | Батлагдсан төсөв | Хянасан нийт орлого батлагдсан төсвийн зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого** | **1** | **2** | **3=(2-1)** | **4** | **5** | **6=(5-4)** | **7** | **8=(7-5)** |
| Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого | **52,298.9** | **57,916.0** | **5,617.1** | **52,298.9** | **58,476.0** | **5,527.1** | **67,126.2** | **8,650.2** |
| Татварын орлого | **52,023.9** | **57,341.0** | **5,317.1** | **52,023.9** | **57,876.0** | **5,852.1** | **66,368.0** | **8,492.0** |
| Орлогын албан татвар | **52,023.9** | **57,341.0** | **5,317.1** | **52,023.9** | **57,876.0** | **5,852.1** | **66,368.0** | **8,492.0** |
| Хувь хүний орлогын албан татвар | **30,149.3** | **33,520.0** | **3,370.7** | **30,149.3** | **33,520.0** | **3,370.7** | **33,520.0** | **-** |
| Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого | 28,819.3 | 30,970.0 | 2,150.7 | 28,819.3 | 30,970.0 | 2,150.7 | 30,970.0 | **-** |
| Үйл ажиллагааны орлого | 250.0 | 260.0 | 10.0 | 250.0 | 260.0 | 10.0 | 260.0 | - |
| Хөрөнгийн орлого | 1,880.0 | 2,600.0 | 720.0 | 1,880.0 | 2,600.0 | 720.0 | 2,600.0 | - |
| Хөрөнгө борлуулсны 2% | 650.0 | 920.0 | 270.0 | 650.0 | 920.0 | 270.0 | 920.0 | - |
| Шууд бус / суутгагчийн хувь хүний орлого/ | 750.0 | 970.0 | 220.0 | 750.0 | 970.0 | 220.0 | 970.0 | - |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | - 2,200.0 | - 2,200.0 | - | - 2,200.0 | - 2,200.0 | - | - 2,200.0 | - |
| Хөрөнгийн татвар | **8,376.0** | **8,391.0** | **15.0** | **8,376.0** | **8,926.0** | **550.0** | **8,926.0** | - |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 7,500.0 | 7,500.0 | - | 7,500.0 | 7,996.0 | 496.0 | 7,996.0 | - |
| Бууны албан татвар | 26.0 | 35.0 | 9.0 | 26.0 | 35.0 | 9.0 | 35.0 | - |
| Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 850.0 | 856.0 | 6.0 | 850.0 | 895.0 | 45.0 | 895.0 | - |
| Бусад татвар | **13,498.6** | **15,430.0** | **1,931.4** | **13,498.6** | **15,430.0** | **1,931.4** | **23,922.0** | **8,492.0** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 360.0 | 435.0 | 75.0 | 360.0 | 435.0 | 75.0 | 435.0 | - |
| ТХАМА-ны төлбөр | 23.0 | 25.0 | 2.0 | 23.0 | 25.0 | 2.0 | 25.0 | - |
| Хог хаягдлын хураамж | 547.0 | 547.0 | - | 547.0 | 547.0 | - | 547.0 | - |
| Газрын төлбөр | 12,277.8 | 14,100.0 | 1,822.2 | 12,277.8 | 14,100.0 | 1,822.2 | 22,600.0 | 8,500.0 |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 5.8 | 8.0 | 2.2 | 5.8 | 8.0 | 2.2 | - | - 8.0 |
| Ус рашаан нөөц ашигласны төлбөр | 285.0 | 315.0 | 30.0 | 285.0 | 315.0 | 30.0 | 315.0 | - |
| Татварын бус орлого | **275.0** | **575.0** | **300.0** | **275.0** | **600.0** | **- 325.0** | **758.2** | **158.2** |
| Төсвийн байгууллагын өөрийн орлого | | | - | | | - | 74.5 | 74.50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүү торгуулийн орлого | 275.0 | 575.0 | 300.0 | 275.0 | 600.0 | 325.0 | 683.7 | 83.7 |

Сангийн яамнаас суурь орлогын саналыг хянахдаа 5,617.1 сая төгрөгөөр, нийт орлогын саналыг 5,527.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж хянасан байна.

Харин хянасан нийт орлогоос АИТХ-аар батлахдаа 8,650.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийн нийт орлогыг 67,126.2 сая төгрөгөөр баталжээ.

Сангийн яамнаас хянасан орлогоос газрын төлбөрийн орлогыг 8,500.0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 83.7 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын өөрийн орлогыг 74.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж батлсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор 2020 оны төсвийн нийт орлогыг 131,593.3 сая төгрөгөөр батлсан бөгөөд үүнээс орон нутгийн төсвийн урсгал орлого 67,126.2 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 4,856.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 44,032.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлого 253.9 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих 14,293.0 сая төгрөг, урьд оны ОНХС-ийн шилжих үлдэгдлээс санхүүжих 1,031.9 сая төгрөгөөр тус тус батлсан.

Харин ойн нөөц ашигласны төлбөрийг сангийн яам 8.0 сая төгрөгөөр хянасан бол аймгийн ИТХ-аар батлахдаа хасаж баталжээ.

Аймгийн төсвийн зарлагын хяналтын хуудсыг батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд: /сая төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Суурь зарлага /Санал/ | Суурь зарлага /Хянасан/ | Зөрүү | Батлагдсан төсөв | Хянасан нийт зардал батлагдсан төсвийн зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.00 | 2.00 | 3=(2-1) | 4.00 | 5=(4-2) |
| 1 | Аймгийн ИТХ | 989.60 | 253.80 | -735.80 | 1,010.40 | 756.60 |
| 2 | Сумдын ИТХ | 448.50 | 175.70 | -272.80 | 405.90 | 230.20 |
| 3 | Аймгийн ЗДТГ | 4,228.90 | 3,534.50 | -694.40 | 2,563.30 | -971.20 |
| 4 | Сумдын ЗДТГ | 3,626.60 | 1,835.20 | -1,791.40 | 3,750.50 | 1,915.30 |
| 5 | Санхүү хяналт аудитын алба | 183.40 | 123.20 | -60.20 | 178.30 | 55.10 |
| 6 | Орон нутгийн өмчийн газар | 332.70 | 229.70 | -103.00 | 331.10 | 101.40 |
| 7 | Спортын байгууллагууд | 654.70 | 382.60 | -272.10 | 384.50 | 1.90 |
| 8 | Соёлын байгууллагууд | 1,833.20 | 1,608.70 | -224.50 | 1,143.20 | -465.50 |
| 9 | Хотын захирагчийн алба | 221.80 | 166.70 | -55.10 | 234.90 | 68.20 |
| 10 | Боловсролын байгууллагын тогтмол зардал | 4,258.40 | 3,266.10 | -992.30 | 2,587.70 | -678.40 |
| 11 | Хүүхэд хамгааллын ТШЗ-ийн тогтмол зардал | 41.10 | 36.20 | -4.90 | 23.20 | -13.00 |
| 12 | Анхан шатны эрүүл мэндийн ТЗШ-ийн тогтмол зардал | 43.20 | 29.90 | -13.30 | 166.40 | 136.50 |
| 13 | ГЗБГЗЗГ-ын ТЗШ-ийн тогтмол зардал | 59.60 | 51.80 | -7.80 | 11.40 | -40.40 |
| 14 | Халамжийн сан | 193.30 | 128.40 | -64.90 | 128.40 | 0.00 |
| 15 | Ойн анги | 105.80 | 56.20 | -49.60 | 106.70 | 50.50 |
| 16 | БОАЖГ | 220.70 | 157.30 | -63.40 | 219.80 | 62.50 |
| 17 | БО нөхөн сэргээх | 1,866.70 | 2,225.30 | 358.60 | 1,941.90 | -283.40 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **18** | Хотын нийтийн тээвэр | 2,834.60 | 1,201.20 | -1,633.40 | 1,200.00 | -1.20 |
| **19** | Хот тохижуулах газар | 4,756.80 | 2,526.60 | -2,230.20 | 4,340.80 | 1,814.20 |
| **20** | Мал эмнэлгийн үйлчилгээ | 51.60 | 38.10 | -13.50 | 38.10 | 0.00 |
| **21** | Замын сан | 801.00 | 801.00 | 0.00 | 1,219.20 | 418.20 |
| **22** | Ахмадын хорооны төсөв | 102.60 | 66.80 | -35.80 | 66.80 | 0.00 |
| | **Нийт** | **27,854.80** | **18,895.00** | **-8,959.80** | **22,052.50** | **3,157.50** |

Сангийн яамнаас төсвийн зарлагын саналыг 8,959.8 сая төгрөгөөр бууруулж 18,895.0 сая төгрөгөөр хянасан байна.

Харин аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны 15/03 дугаар тогтоолоор 2020 оны төсвийн зарлагыг сангийн яамны хянасан дүнгээс 3,157.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 22,052.5 сая төгрөгөөр баталсан нь Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийн 4.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа Засгийн газраас баталсан төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сангийн яамны хянасан суурь зардалд дараах орон нутгийн байгууллагууд хянагдаагүй байна. Үүнд:

- Нийтлэг үйлчилгээний алба 594.9 сая төгрөг
- Мэдээлэл шуурхай удирдлагын төв 147.9 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 58.1.14-т “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх” гэж заасны дагуу аймгийн 2020 оны төсөвт 1,941.9 сая төгрөгийг Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд баталсан бөгөөд тус зардалд Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагааны зардал 370.7 сая төгрөгийг оруулан баталсан байна.

**1.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Эрдэнэт сангийн төсөв батлахдаа ОНӨҮГ-т санхүүжилт олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зүйл заалттай нийцэхгүй байна.**

Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-т “ дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг үндэслэн 2020 оны төсөвт тодотгол хийсэн байна.

Төсвийн орлогод орсон өөрчлөлт: /сая.төгрөг/

| № | Аймгийн төсвийн орлого | АИТХ 2019.11.29 15/03 | АИТХ 2020.09.07 01 | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3=(2-1) |
| 1 | Газрын төлбөр | 22,600.00 | 22,158.86 | -441.14 |
| 2 | ОНХС-ын орлогын шилжүүлэг | 4,856.02 | 4,295.94 | -560.08 |
| 3 | Тусгай зориулалтын шилжүүлэг | 44,032.20 | 43,513.87 | -518.33 |
| 4 | Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих | 14,293.02 | 18,706.35 | 4,413.33 |
| 5 | Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих ОНХС | 1,031.89 | 749.53 | -282.36 |
| | **Нийт** | **86,813.12** | **89,424.54** | **2,611.42** |

Дээрх хүснэгтээс үзэхэд Газрын төлбөрийн орлогыг анх 22,600.0 сая төгрөгөөр баталсныг 441.1 сая төгрөгөөр бууруулж 22,158.9 сая төгрөг, ОНХС-ын орлогын шилжүүлгийг 560.1 сая төгрөгөөр бууруулж 4,295.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийг 518.3 сая төгрөгөөр бууруулж 43,513.9 сая төгрөг, урьд оны ОНХС-ийн шилжих үлдэгдлээс санхүүжих зардлыг 282.4 сая төгрөгөөр бууруулж 749.5 сая төгрөг болгож өөрчилсөн байна.

Төсвийн зарлагад орсон тодотгол: /сая.төгрөг/

| № | Нэрс | 2019.11.29 15/03 | 2020.09.07 01 | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3=(2-1) |
| 1 | Санхүүгийн хяналт, аудитын алба | 178.28 | 179.48 | 1.20 |
| 2 | Ахмад настны байгууллагад орон нутгаас олгох санхүүжилт | 66.79 | 75.02 | 8.23 |
| 3 | Сумдын соёлын төв | 650.27 | 649.07 | -1.20 |
| | **Дүн** | **895.34** | **903.57** | **8.23** |
| 4 | хо ЗАРДАЛ | 21,276.40 | 24,929.44 | 3,653.05 |
| 5 | Төсөл хөтөлбөрийн зардал | 7,513.55 | 8,265.60 | 752.06 |
| | **ОНХО дүн** | **28,789.94** | **33,195.04** | **4,405.10** |
| 6 | хо ЗАРДАЛ | 3,702.53 | 2,776.08 | -926.45 |
| 7 | Төсөл хөтөлбөрийн зардал | 114.30 | 100.00 | -14.30 |
| | **ОНХС дүн** | **3,816.83** | **2,876.08** | **- 940.75** |
| 8 | БӨ | 826.63 | 873.18 | 46.54 |
| 9 | Жаргалант | 943.32 | 995.09 | 51.77 |
| | **Дүн** | **1,769.95** | **1,868.26** | **98.31** |
| 10 | СӨБ-ийн тусгай зориулалтын шилжүүлэг | 15,214.00 | 14,867.89 | 346.11 |
| 11 | ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлэг | 23,747.97 | 23,575.75 | 172.22 |
| 12 | Орон нутгийн төсвөөс | 1,352.79 | 1,352.19 | 0.60 |
| | **Нийт** | **40,314.76** | **39,795.83** | **518.93** |
| 13 | ГХБХБГ Орон нутгийн төсвөөс | 10.80 | 11.40 | -0.60 |
| | **Нийт** | **75,597.63** | **78,650.19** | **3,052.56** |

Төсвийн зарлагад тодотгол хийсэн байдлыг үзэхэд: Сумдын соёлын төвийн санхүүжилтээс 1.2 сая төгрөг хасаж, СХАА-нд 1.2 сая төгрөг нэмсэн бол ахмад настны байгууллагад орон нутгаас олгох санхүүжилтийг 8.23 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

ОНХО-ын төсөл арга хэмжээг 4,405.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 33,195.0 сая төгрөг, ОНХС-ийн төсөл арга хэмжээг 940.8 сая төгрөгөөр бууруулж 2,876.1 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Сумдад олгох санхүүжилтийг 98.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,868.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийг 518.9 сая төгрөгөөр бууруулж 39,795.8 сая төгрөг болгон тодотгол хийсэн байна.

ГХБХБГ-ын орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 0.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11.4 сая төгрөг болгосон байна.

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар Орхон аймаг 2020 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 29,220.1 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 15/04 дүгээр тогтоолд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 29,661.3 сая төгрөг, 2020 оны 01 дүгээр тогтоолд 29,220.1 сая төгрөг болгон 441.1 сая төгрөгөөр бууруулан тодотгол хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 15/04 дүгээр тогтоолоор “Орон нутаг хөгжүүлэх Эрдэнэт сангийн 2020 оны орлого, тус сангийн санхүүжилтээр хийгдэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардал”-ыг баталсан бөгөөд сангийн орлогыг 6,077.6 сая төгрөг, зардлыг 6,077.6 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Эрдэнэт сангийн дүрмийг баталсан.

Уг дүрэмд зааснаар тус сан нь аймаг хөгжүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулж, нийгэмд ашиг тустай хот байгуулалт, тохижилт дэд бүтцийг хөгжүүлэх, аймгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой гэж заасан.

Харин тус Сангаас “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ын үйл ажиллагааны зардал 64.9 сая төгрөг, “Хөх Монгол” цогцолборын үйл ажиллагааны зардал 75.3 сая төгрөг, нийт 140.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрдэнэт сангийн орлогыг аймгийн ИТХ-ын 2019 оны 15/04 дүгээр тогтоолоор 6,077.5 сая төгрөгөөр баталсан бол 2020 оны 01 дүгээр тогтоолоор 12,472.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,549.6 сая төгрөг болгон тодотгосон байна.

АИТХ-ын 2019 оны 11 сарын 29-ний 15/03 дугаар тогтоолоор 2020 онд шилжих хөрөнгө оруулалт 76 төсөл арга хэмжээнд 7,675.9 сая төгрөг, шинэ эхлэх орон нутгийн хөрөнгө оруулалтаар 169 төсөл арга хэмжээнд 13,600.5 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн 167 төсөл арга хэмжээнд 7,513.5 сая төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 34 төсөл арга хэмжээг 1,941.9 сая төгрөг, Авто замын сангийн хөрөнгөөр 17 төсөл арга хэмжээг 1,219.2 сая төгрөгөөр санхүүжүүлж гүйцэтгэхээр баталсан байна.Үүнд:

Хөрөнгө оруулалтын төлөвлө: /сая төгрөг/

| № | Хөрөнгө оруулалтын задаргаа | ТАХ-ний | Батлагдсан мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт | 169 | 13,600.5 |
| 2 | Шилжих үлдэгдлээр | 76 | 7,675.9 |
| 3 | Байгаль хамгаалах арга хэмжээ | 34 | 1,941.9 |
| 4 | Авто замын сан | 17 | 1,219.2 |
| 5 | Төсөл хөтөлбөр | 167 | 7,513.5 |
| 6 | Нийт | 463 | 31,951.0 |

Аймгийн ИТХ-ын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 16/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн 6 төсөл арга хэмжээний нэршлийг өөрчилж 5 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн 1 төсөл арга хэмжээний нэршлийг, Эрдэнэт сангийн хөрөнгөөр хэрэгжих 2 төсөл арга хэмжээний нэршлийг өөрчилсөн байна.

Нэршил өөрчилсөн 7 төсөл арга хэмжээний 714.8 сая төгрөгийн ажлыг 24 төсөл арга хэмжээ болгон хуваасан байна. Эдгээр төсөл арга хэмжээний нэр өөрчлөгдөхөд ажлын зураг, төсөв өөрчлөгдөх ёстой боловч дахин зураг төсөв хийхгүйгээр хуучин зураг төсвөөр хийгдэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчсөн байна.

**1.3 Жаргалант сумын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг энэ онд санхүүжихээр эх үүсвэр талд баталсан нь Төсвийн тухай хуулийн 60.2 дах хэсгийг зөрчсөн байна.**

**Баян-Өндөр сум:** Баян-өндөр сумын ИТХ-ын 2019 оны 12 сарын 18-ны ээлжит 14-р хуралдааны 05 дугаар тогтоолоор Баян-өндөр сумын 2020 оны төсвийг батлахдаа ИТХ-ын урсгал зардлыг 226.5 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 2,577.2 сая төгрөг, нийт 2,803.7 сая төгрөгөөр баталсан.

ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 275.5 сая төгрөг аймгийн ИТХ-аас сумдад хуваарилсан ОНХС-ийн санхүүжилт 826.6 сая төгрөг, алданги тендерийн хэмнэлт, магадлашгүй ажил 23.1 сая төгрөг, нийт 1,125.2 сая төгрөг баталжээ.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны 3 дугаар тогтоолоор ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 46.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 873.2 сая төгрөг болгож тодотгосон байна.

**Жаргалант сум:** Жаргалант сумын ИТХ-ын 2019 оны 12 сарын 17-ний өдрийн 6 дугаар тогтоолоор сумын нийт татварын орлогыг 50.0 сая төгрөгөөр, ИТХ-ын урсгал зардлыг 182.4 сая төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 1,135.8 сая төгрөг, нийт 1,318.2 сая төгрөгөөр баталсан.

ОНХС-ийн санхүүжилтийг аймгийн ОНХС-аас хуваарилсан 943.3 сая төгрөг, урьд оны ОНХС-ын шилжих үлдэгдлээс 161.7 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдлээс 152.2 сая төгрөг нийт 1,257.3 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-нд сумын төсвийн байгууллагын өмнөх оны төсвийн хэмнэлт болгож ерөнхий орлогод төвлөрүүлсэн 152.2 сая төгрөгийг 2020 онд ОНХС-д санхүүжих эх үүсвэр болгон баталсан нь Төсвийн тухай хуулийн 60.2-т “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 60.2.1-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг”, 60.2.2-т “энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө”, 60.2.5-д “тухайн тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”, 60.2.6-д “Ашигт малтмалын тухай хуулийн $47^3$ дугаар зүйлд заасанаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь”, 60.2.7-д “ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь”, 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Жаргалант сум нь төсөв батлахдаа татварын орлого, тусламжийн орлого, сум хөгжүүлэх сангийн орлого, сумын ИТХ, ЗДТГ, ЕБС, эрүүл мэндийн төв, соёл мэдээллийн төв, ОНХС зэрэг 7 санхүүгийн тайлан гаргадаг байгууллагын төсвийг сумын ИТХ-аар баталдаг байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Жаргалант сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагч байтал Төсвийн тухай хуулийн 8.9.2-т “төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж зааснаар сумын төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэн тайлагнаж, аудитад хамрагддаггүй байна.

Иймд төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлагнаж байх шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн зарим орлого тасарсан боловч цар тахалтай холбоотойгоор хэмнэлт үүссэн, боловсролын байгууллагууд төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

**2.1 Газрын төлбөрийн орлого 2,710.0 сая төгрөг, хог хаягдлын хураамж 22.8 сая төгрөгөөр тасарсан байна.**

Аймгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзвэл 15 нэр төрлийн татварын орлого 107.7 хувь буюу 5,094.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогыг нэр төрлөөр үзүүлбэл: /сая.төгрөг/

| Орлогын нэр төрөл | 2019 оны гүйцэтгэл | 2020 он | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Татварын орлого | **33309.90** | **33538.00** | **40095.40** | **-6557.40** | **119.55** |
| Цалин хөлс түүнтэй адилтгах орлого | 30527.40 | 30970.00 | 35767.90 | -4797.90 | 115.49 |
| Үйл ажиллагааны орлого | 406.80 | 265.00 | 440.50 | -175.50 | 166.23 |
| Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/ | 2560.70 | 2609.00 | 3194.40 | -585.40 | 122.44 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 886.70 | 923.50 | 1168.10 | -244.60 | 126.49 |
| Шууд бус орлого | 1072.50 | 970.50 | 1508.50 | -538.00 | 155.44 |
| ХХОАТ-ын буцаалт | -2144.20 | -2200.00 | -1984.00 | -216.00 | 90.18 |
| хөрөнгийн албан татвар | **9171.60** | **8926.90** | **9511.40** | **-584.50** | |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | 8211.70 | 7996.00 | 8459.90 | -463.90 | 105.80 |
| Бууны татвар | 30.60 | 35.90 | 37.90 | -2.00 | 105.57 |
| АТБӨЯХАТатвар | 929.30 | 895.00 | 1013.60 | -118.60 | 113.25 |
| Бусад татвар төлбөр хураамж | **1572.30** | **1024.50** | **1653.40** | **-628.90** | **161.39** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 434.40 | 437.70 | 694.80 | -257.10 | 158.74 |
| ТТАМ-н ОАТ | 32.50 | 38.80 | 44.10 | -5.30 | 113.66 |
| Хог хаягдлын хураамж | 519.60 | 548.00 | 525.20 | 22.80 | 95.84 |
| Бусад татвар | 585.80 | 0.00 | 389.30 | -389.30 | |
| Газрын төлбөр | **20135.60** | **22171.40** | **19461.40** | **2710.00** | **87.78** |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | **338.00** | **322.80** | **356.30** | **-33.50** | **110.38** |
| Ойн нөөц ашигласны | 7.40 | 6.00 | 16.80 | -10.80 | 280.00 |
| Ус рашааны нөөц ашигласны | 330.60 | 316.80 | 339.50 | -22.70 | 107.17 |
| **Нийт дүн** | **64527.40** | **65983.60** | **71077.90** | **-5094.30** | **107.72** |

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2020 оны татварын орлогыг 65,983.6 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 71,077.9 сая төгрөг төвлөрч 5,094.3 сая төгрөг буюу 7.7 хувиар давж биелсэн байна. Давсан орлогын шалтгааныг тогтооход дараах байдалтай байна. Тухайлбал:

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар**ын орлогыг 30,970.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 35,767.9 сая төгрөг төвлөрч, 4,797.9 сая төгрөг буюу 15.5 хувиар давсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдын цалин сүлжээ шинэчлэгдэн батлагдсантай холбоотой байна.
- **Хөрөнгийн орлогын** татварыг 2,609.0 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 3,194.4 сая төгрөг төвлөрч, 585.4 сая төгрөг буюу 22.4 хувиар давсан нь хадгаламжийн эзэмшигчийн тоо нэмэгдэж түүний хүүгийн орлого орон нутагт төвлөрдгөөс шалтгаалсан байна.
- **Үл хөдлөх хөрөнгийн татвар**ыг 7,996.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8,459.9 сая төгрөг төвлөрч, 463.9 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар давсан.

- **Газрын төлбөр**ийн орлогыг 2020 онд 22,171.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19,461.4 сая төгрөг орж, төлөвлөгөөнөөс 2,710.0 сая төгрөгөөр буюу 87.8 хувиар тасарсан нь Уулын баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т жил бүр орон нутгаас усны алдагдлын зөрүүнд 2,040.0 сая төгрөгийг газрын төлбөрт суутган тооцсонтой холбоотой байна.
- **Хог хаягдлын хураамжий**г 548.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 525.2 сая төгрөг төвлөрч, 22.8 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 95.84 хувьтай байгаа нь Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотой байна.

Татварын бус орлогыг нэр төрлөөр харуулбал: /сая.төгрөг/

| Орлогын нэр төрөл | 2019 оны гүйцэтгэл | 2020 он | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **Хүүгийн орлого** | 12.10 | - | 3.70 | - 3.70 | |
| **Торгуулийн орлого** | 1,359.30 | 711.04 | 1,475.70 | - 764.66 | 207.54 |
| **Бусад орлого** | 602.00 | | 304.70 | - 04.70 | |
| **Дүн** | 1,973.4 | 711.04 | **1,784.1** | **773.06** | **207.54** |

2020 онд татварын бус орлого 773.06 сая төгрөг буюу 7.8 хувиар давж биелсэн байна. Давсан орлогын шалтгааныг тогтоохоод дараах байдалтай байна. Үүнд:

- **Торгуулийн орлого:** Тайлант онд 711.04 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,475.7 сая төгрөг төвлөрч, 764.66 сая төгрөгөөр давж биелсэн байна.
- **Хүүгийн орлого, бусад орлого:** Уг орлогуудыг төсөв батлахад тодорхой төлөвлөж баталдаггүй тул орсон орлого нь хэтэрснээр харагдаж байна.

Орон нутагт нэгтгэдэг бусад орлого: /сая.төгрөг/

| Орлогын нэр төрөл | 2020 он | | | |
|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,168.90 | 16,689.30 | - 520.40 | 103.22 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 26.60 | 52.50 | - 25.90 | 197.37 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 23,401.10 | 12,787.70 | 10,613.40 | 54.65 |
| **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **39,596.60** | **29,529.50** | **10,067.10** | |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 43,483.80 | 43,234.80 | 249.00 | 99.43 |
| ОНХС-ийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 4,295.90 | 4,006.50 | 289.40 | 93.26 |
| **Улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **47,779.70** | **47,241.30** | **538.40** | 98.87 |
| **Нийт дүн** | **87,376.30** | **76,770.80** | **10,605.50** | |

**2.2 Төсвийн зардлын хэмнэлт нь ковид 19 цар тахалтай холбоотойгоор Сангийн яамнаас зарим зардалд хязгаарлалт хийснээс шалтгаалж төсвийн гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна.**

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 32,916.0 сая төгрөг буюу 33%-аар өссөн байна.

Тус онд орон нутгийн төсвөөс 154,100.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээс бараа үйлчилгээний зардалд 89,195.5 сая төгрөг буюу 57.8%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 29,564.9 сая төгрөг буюу 19.1%, урсгал шилжүүлэгт 30,886.0 сая төгрөг буюу 20.0%, хөрөнгийн зардалд 29,001.0 сая төгрөг буюу 18.8%-ийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

2020 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

| Зарлагын нэр төрөл | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны Төлөвлөгөө | 2020 оны Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **99,548.75** | **154,100.97** | **132,464.73** | **21,636.24** | 86.0 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **78,173.83** | **121,281.60** | **107,505.55** | **13,776.05** | 88.6 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **59,390.50** | **89,195.59** | **75,565.90** | **13,629.69** | 84.7 |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 33,431.88 | 40,496.65 | 40,146.41 | 350.24 | 99.1 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,220.81 | 5,229.94 | 5,152.86 | 77.07 | 98.5 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,632.67 | 3,358.92 | 2,322.44 | 1036.48 | 69.1 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 1,457.00 | 2,112.78 | 1,978.22 | 134.56 | 93.6 |
| **Норматив зардал** | 2,018.04 | 3,266.92 | 2,530.63 | 736.29 | 77.5 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 698.86 | 908.08 | 796.56 | 111.52 | 87.7 |
| **Томилолт, зочны зардал** | 377.93 | 152.62 | 114.47 | 38.15 | 75 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | **11,926.32** | **29,564.97** | **18,691.93** | **10,873.04** | 63.2 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 11,795.03 | 29,373.34 | 18,516.39 | 10,856.94 | 63 |
| **Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох** | 32.48 | 66.21 | 58.31 | 7.9 | 88.1 |
| **Даатгалын үйлчилгээ** | 32.42 | 35.25 | 34.14 | 1.11 | 96.8 |
| **Тээврийн хэрэгслийн татвар** | 6.58 | 7.51 | 6.85 | 0.66 | 91.2 |
| **Тээврийн хэрэгслийн оношилгоо** | 2.48 | 2.68 | 2.36 | 0.32 | 88 |
| **Мэдээлэл, технологийн үйлчилгээ** | 20.07 | 24.47 | 24.3 | 0.17 | 99.3 |
| **Газрын төлбөр** | 36.95 | 54.08 | 49.19 | 4.88 | 91 |
| **Банк, СБ-ын үйлчилгээний хураамж** | 0.31 | 1.43 | 0.39 | 1.04 | 27.7 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,626.99** | **4,104.63** | **3,832.31** | **272.32** | 93.4 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,351.03 | 3,554.98 | 3,482.25 | 72.73 | 98 |
| **Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх** | 275.96 | 549.65 | 350.06 | 199.59 | 63.7 |
| **ТАТААС** | **845.84** | **1200.00** | **1127.89** | **72.1** | 94 |
| **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 845.84 | 1200.00 | 1127.89 | 72.1 | 94 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,937.49** | **30,886.00** | **30,811.75** | 74.25 | 99.8 |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 16,465.92 | 29,375.14 | 29,375.14 | 0 | 100 |
| **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | 16,465.92 | 29,375.14 | 29,375.14 | 0 | 100 |
| Бусад урсгал шилжүүлэг | **1,471.57** | **1,510.84** | **1,436.58** | **74.26** | 95.73 |
| **Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж** | 124.3 | 128.38 | 103.92 | 24.46 | 81 |
| **Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал** | 102.2 | 321.53 | 294.97 | 26.56 | 91.7 |
| **Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал** | 971.02 | 505.07 | 503.29 | 1.78 | 99.6 |
| **Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж** | 58.08 | 247.09 | 238.73 | 8.36 | 96.6 |
| **Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт** | 2.8 | 0.9 | 0.6 | 0.3 | 66.7 |
| **Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал** | 213.17 | 307.87 | 295.07 | 12.8 | 95.8 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,918.18** | **29,001.04** | **20,918.18** | **8,082.86** | 72.13 |
| **Барилга байгууламж** | 3,661.39 | 4,657.61 | 3,329.25 | 1,328.36 | 71.5 |
| **Их засвар** | 14,698.60 | 23,650.90 | 18,918.47 | 4,732.43 | 80 |
| **Тоног төхөөрөмж** | 2,558.19 | 3,820.16 | 2,333.28 | 1,486.87 | 61.1 |
| **Бусад хөрөнгө** | | 75.00 | | 75.00 | |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | **456.74** | **615.69** | **378.15** | **237.54** | 61.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Эргэж төлөгдөх зээл** | 456.74 | 615.69 | 378.15 | 237.54 | 61.4 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **100,177.98** | **154,100.97** | **139,495.03** | **14,605.94** | 90.5 |
| Улсын төсвөөс санхүүжих | 39,420.95 | 47,779.68 | 46,514.08 | 1265.6 | 99.95 |
| **Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих** | 34,448.47 | 43,483.75 | 42,507.61 | 976.14 | 99.94 |
| **Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих** | 4,972.48 | 4,295.93 | 4,006.47 | 289.46 | 100 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | **56,883.59** | **65,196.46** | **56,883.59** | **8,312.87** | 87.25 |
| **Орон нутгийн төсвөөс** | 56,883.59 | 66,694.59 | 63,438.18 | 3,256.41 | 95.1 |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | **29.26** | **30.11** | **30.11** | 0 | 100 |
| **Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих** | 29.26 | 30.11 | 30.11 | 0 | 100 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | **3,844.18** | **39,596.58** | **29,512.64** | **10,083.93** | 74.5 |
| **Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас** | 3,816.76 | 16,195.53 | 16,724.93 | -529.40 | 103.1 |

Тайлант оны төсвийн хэмнэлт дараах шалтгаанuудаас үүдэлтэй байна. Үүнд:

- Цалин, хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал 427.31 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан нь 2-р сургууль 5.1 сая төгрөг, 8-р сургууль 6.1 сая төгрөг, аймгийн ИТХ 6.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ 4.3 сая төгрөг, Баянцагаан соёлын төв 5.1 сая төгрөг, Орон нутгийн музей 11.3 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээний алба 7.5 сая төгрөг, Сум дундын ойн анги 8.9 сая төгрөг, Орон нутгийн өмчийн газар 15.8 сая төгрөг, Санхүү хяналт аудитын алба 12.9 сая, Хотын захирагчийн алба 29.6 сая төгрөг, Хүүхэлдэйн театр 82.9 сая төгрөг, Жаргалант сумын ИТХ 10.3 сая төгрөг гэх мэт нийт 19 байгууллагын 233.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд эдгээр байгууллагууд нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,036.48 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь тус онд ашиглалтад орохоор төлөвлөж байсан сургууль, цэцэрлэгийн ашиглалтын зардал, сургууль цэцэрлэгүүдийн ажиллаагүй үеийн ашиглалтын зардлууд хэмнэгдэж үлдсэн байна.
- Нормативт зардал, томилолт, төлбөр хураамжийн зардлуудад Ковид 19-тэй холбоотой сангийн яамнаас хязгаарлалт тогтоосон, сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой хэмнэлт гарсан байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 10,856.94 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь төсөл хөтөлбөрийн зарим ажлууд хийгдээгүй гүйцэтгэл гараагүйтэй холбоотой байна.
- Хөрөнгийн зардал 8,082.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ажлын гүйцэтгэл гараагүй, худалдан авах ажиллагаа хойшлогдон, зарим ажлууд он дамжиж, дараа онд шилжиж үлдсэнтэй холбоотой байна.

**<u>Ковид 19 цар тахал:</u>** Тайлант онд Ковид 19 цар тахалтай холбоотой тусгай шилжүүлгийн 47 байгууллага 130.9 сая төгрөгийг бараа материалд, 12.5 сая төгрөгийг тоног төхөөрөмжид, 135.3 сая төгрөгийг ариутгал цэвэрлэгээний зардалд, 21.9 сая төгрөгийг ажлын хөлс, илүү цагийн хөлс, 23.1 сая төгрөгийг бусад зардалд, нийт 370.7 сая төгрөг зарцуулсан.

Орон нутгийн төсвийн 27 байгууллага 75.9 сая төгрөг бараа материалд, 8.4 сая төгрөгийг тоног төхөөрөмжид, 43.3 сая төгрөгийг ариутгал цэвэрлэгээний зардалд, 80.9 сая төгрөгийг ажлын хөлс, илүү цагийн хөлс, 14.5 сая төгрөгийг бусад зардалд нийт 250.0 сая төгрөг зарцуулжээ.

Орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж 11.4 сая төгрөгийг бараа материалд, 0.7 сая төгрөгийг тоног төхөөрөмжид, 1.1 сая төгрөгийг ариутгал цэвэрлэгээний зардалд, 0.24 сая төгрөгийг бусад зардалд, нийт 12.81 сая төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн төсөвт нэгтгэгддэг байгууллагын ковидтой холбоотой зардлыг харуулбал: /сая.төгрөг/

| № | Байгууллагын нэр | Байгууллагын тоо | Зардлын нийт дүн /төг/ | | | | | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бараа материалын дүн | Тоног төхөөрөмжийн дүн | Ариутгал, цэвэрлэгээний зардал | Ажлын хөлс, илүү цагийн мөнгө | Бусад | |
| 1 | Тусгай шилжүүлгийн байгууллагууд | 47 | 130.9 | 12.5 | 135.3 | 21.9 | 23.1 | 323.7 |
| 2 | Орон нутгийн төсөвт байгууулагууд | 27 | 75.9 | 8.4 | 43.3 | 80.9 | 14.5 | 223.0 |
| 3 | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд | 7 | 11.4 | 0.07 | 1.1 | | 0.24 | 12.81 |
| | **Нийт дүн** | **81** | **218.2** | **20.97** | **179.7** | **102.8** | **37.84** | **559.51** |

Дээрх хүснэгтээс үзэхэд орон нутгийн 81 байгууллага аж ахуйн нэгж Ковид цар тахалтай холбоотойгоор нийт 559.5 сая төгрөгийг төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн төсөвт 6 байгууллага болон орон нутгийн төсөл хөтөлбөрөөс 19 хэвлэл мэдээлэл, радио телевизийн байгууллагуудад хамтран ажиллах гэрээнд зааснаар байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг мэдээлэхэд зориулж нийт 309.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн эсэх нь тодорхойгүй, гэрээнд тусгагдсан мэдээллүүд хоорондоо давхардал бий болгосон эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 4.1.36-т “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд орон нутгийн байгууллагуудын хэвлэл мэдээллийн зардлыг зүй зохистой арвилан хэмнэлттэй байхаар зарцуулахад хяналт тавьж, мэдээлэх мэдээлэл давхардаж буй эсэхийг хэвлэл мэдээллийн ажилтнууд бүрэн хянаж баталгаажуулсны дараа санхүүжилтийг олгож байх шаардлагатай байна.

Орон нутгийн төсөвт байгууллагаас санхүүжигдсэн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хүснэгтээр харуулбал: /сая.төгрөг/

| № | Хэвлэл мэдээллийн байгууллагын нэрс | Аймгийн ИТХ | Баян-өндөр сумын ЗДТГ | Төсөл хөтөлбөр | Аймгийн ЗДТГ | Хотын Захирагчийн алба | Жаргалант сумын ЗДТГ | Жаргалант сумын ИТХ | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Номин макс | 11.0 | 1.0 | 25.6 | | | | | 37.6 |
| 2 | Эрдэнэт таймс сонин | 4.0 | 1.0 | 40.7 | | | | | 45.7 |
| 3 | Тэнгэр ТВ /Бунадо ХХК/ | | 1.0 | 10.5 | | | | | 11.5 |
| 4 | Сэтгүүлчдийн цахим сүлжээ НҮТББ /erdenetlife.mn/ | 3.0 | 1.0 | 16.5 | | | | | 20.5 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5** | Etimess.mn /Дэлгэрэх анд оюу ХХК/ | 3.0 | 1.0 | 9.0 | | | | | 13.0 |
| **6** | Үгийн хүч НҮТББ//FM104 радио/ | | 0.5 | 4.0 | | | | | 4.5 |
| **7** | Тусгал ТВ /Очир роуд ХХК/ | 4.0 | 1.0 | 8.5 | | | | | 13.5 |
| **8** | ETZONE сайт /Итгэлийн мод ТББ/ | | 1.0 | 51.0 | | | | | 52.0 |
| **9** | Gereg.mn /УЦСББХ ХХК/ | | 1.0 | 5.0 | | | | | 6.0 |
| **10** | Хэнзо интертаймент ХХК | | 1.5 | 8.6 | | | | | 10.1 |
| **1** | Цахим эрдэнэт ТББ | | | 9.0 | | 10.0 | | | 19.0 |
| **12** | Нар туссан цаг | 3.0 | | 3.0 | 1.5 | | 0.8 | | 8.3 |
| **13** | Ишилан ХХК | 3.0 | | 26.4 | | | | | 29.4 |
| **14** | Итгэлийн мод ТББ | 1.5 | | | | | | | 1.5 |
| **15** | Колор филмс ХХК | 2.0 | | 15.2 | | | | 1.0 | 18.2 |
| **16** | Тунгалаг засаглал ТББ | 1.5 | | 8.7 | | | | | 10.2 |
| **17** | Макс арт | 3.0 | | | | | | | 3.0 |
| **18** | Очир аяга /Tac.mn/ | 2.0 | | 2.5 | | | | | 4.5 |
| **19** | Санал асуулгын үндэсний төв | 1.0 | | | | | | | 1.0 |
| | **Нийт дүн** | **42.0** | **10.0** | **244.2** | **1.5** | **10.0** | **0.8** | **1.0** | **309.5** |

**2.3 Тусгай шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг бодитой төлөвлөөгүйгээс 281.2 сая төгрөгийн хэмнэлт үүсч, цалингийн зардлын хэмнэлтээс 339.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

**2.3.1 Сургуулийн өмнөх боловсролын салбарын тогтмол зардлыг орон нутгаас олгохдоо бодитой төлөвлөөгүйгээс 180.12 сая төгрөгийн хэмнэлт үүссэн, цалингийн хэмнэлтээс урамшуулалд 96.2 сая төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Орхон аймгийн ИТХ-ын 2019 оны 11-р сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын тусгай шилжүүлгийн санхүүжилтийг 15,214.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 1,234.9 сая төгрөг, нийт 16,448.9 сая төгрөгөөр баталсан.

ИТХ-ын ээлжит бус хуралдааны 2020 оны 09-р сарын 07-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын тусгай шилжүүлгийн санхүүжилтийг 14,867.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 1,234.9 сая нийт 16,102.8 сая төгрөг болгон 346.1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11-р сарын 13-ны өдрийн 1а/2788 дугаарын албан бичгийн дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 11-р сарын 30-ний өдрийн 02/04 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын тусгай шилжүүлгийн нийт санхүүжилтийг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 16,202.8 сая төгрөгөөр баталжээ.

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгийн өдрийн бүлэгт 7,135 хүүхэд суралцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр 7,542 хүүхэд хамруулж, төлөвлөснөөс 407 хүүхэд илүү хамруулжээ.

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгт 535 багш бусад ажилтан 450 нийт 985 багш, ажилчид ажиллажээ.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулсан сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэг, хувийн 8 цэцэрлэг нь орон нутгийн төсвөөс 1,117.6 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөн гүйцэтгэлээр 855.2 сая төгрөг зарцуулан орон нутгийн төсөвт 322.4 сая, тусгай шилжүүлгийн санхүүжилтээр 13,806.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэлээр 13,735.8 сая төгрөг зарцуулж, 52.9 сая төгрөг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын санхүүжилтийн тооцоо

/сая төгрөг/

| д/д | Байгууллагын нэр | ОН-ийн санхүүжилт | Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн | Цэвэр санхүүжилт | ТЗШ-ийн санхүүжилт | Улсын төсөвт төвлөрүүлсэн | Цэвэр санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | I цэцэрлэг | 41.22 | 6.78 | 34.44 | 596.95 | 0.872 | 596.08 |
| 2 | II цэцэрлэг | 16.05 | 0.00 | 16.05 | 362.58 | 1.2591 | 361.32 |
| 3 | III цэцэрлэг | 47.21 | 0.45 | 46.76 | 366.41 | 6.1409 | 360.27 |
| 4 | IY цэцэрлэг | 52.34 | 10.39 | 41.94 | 612.96 | 0.4275 | 612.53 |
| 5 | Y цэцэрлэг | 42.27 | 18.72 | 23.55 | 365.69 | 1.0779 | 364.62 |
| 6 | YI цэцэрлэг | 34.12 | 15.66 | 18.46 | 365.33 | 1.5126 | 363.82 |
| 7 | YII цэцэрлэг | 68.42 | 0.19 | 68.24 | 636.76 | 0.933 | 635.83 |
| 8 | YIII цэцэрлэг | 43.63 | 14.75 | 28.88 | 376.45 | 0.8603 | 375.59 |
| 9 | IX цэцэрлэг | 38.42 | 11.91 | 26.51 | 385.69 | 1.7893 | 383.90 |
| 10 | X цэцэрлэг | 40.78 | 16.30 | 24.49 | 376.84 | 0.4053 | 376.44 |
| 11 | XI цэцэрлэг | 63.36 | 2.86 | 60.50 | 403.48 | 0.7887 | 402.69 |
| 12 | XY цэцэрлэг | 56.63 | 22.00 | 34.63 | 615.81 | 0.5918 | 615.22 |
| 13 | XYI цэцэрлэг | 37.87 | 14.64 | 23.23 | 373.52 | 0.081 | 373.44 |
| 14 | XYII цэцэрлэг | 54.80 | 15.51 | 39.29 | 606.64 | 4.7127 | 601.93 |
| 15 | XYIII цэцэрлэг | 28.34 | 0.12 | 28.22 | 411.14 | 0.1992 | 410.95 |
| 16 | XIX цэцэрлэг | 35.13 | 15.04 | 20.09 | 379.07 | 2.5197 | 376.55 |
| 17 | XX цэцэрлэг | 31.87 | 9.87 | 22.00 | 494.34 | 3.2562 | 491.08 |
| 18 | XXI цэцэрлэг | 51.88 | 10.29 | 41.59 | 611.74 | 1.8494 | 609.89 |
| 19 | XXII цэцэрлэг | 42.22 | 14.01 | 28.21 | 514.17 | 4.6632 | 509.51 |
| 20 | XXIII цэцэрлэг | 58.17 | 23.49 | 34.68 | 491.60 | 0.6424 | 490.96 |
| 21 | XXIV цэцэрлэг | 21.77 | 9.53 | 12.24 | 404.61 | 0.2087 | 404.40 |
| 22 | XXVI цэцэрлэг | 55.83 | 28.94 | 26.89 | 546.78 | 2.0105 | 544.77 |
| 23 | XXVII цэцэрлэг | 0.57 | - | 0.57 | 90.79 | 0.6256 | 90.17 |
| 24 | Дэгдээхэй цэцэрлэг | 38.23 | 7.52 | 30.71 | 560.03 | 4.4677 | 555.56 |
| 25 | Оюу цэцэрлэг | 41.52 | 8.50 | 33.02 | 555.24 | 5.1764 | 550.07 |
| 26 | Бялзуухай цэцэрлэг | 39.95 | 12.44 | 27.51 | 358.04 | 0.0521 | 357.99 |
| 27 | Одод цэцэрлэг | 29.18 | 5.18 | 24.00 | 361.14 | 0.1853 | 360.96 |
| 28 | Унага цэцэрлэг | 44.34 | 14.16 | 30.18 | 509.84 | 1.1963 | 508.65 |
| 29 | Эрх бужинхэн цэцэрлэг | 21.51 | 13.15 | 8.36 | 239.47 | 4.4877 | 234.98 |
| 30 | Хувийн цэцэрлэг | - | - | - | 833.67 | 0.0006 | 833.67 |
| ДҮН | | **1,177.63** | **322.40** | **855.23** | **13,806.80** | **52.99** | **13,753.80** |

Дээрхээс үзэхэд цэцэрлэгүүдийн буцаан төвлөрүүлсэн санхүүжилт нь харилцан адилгүй байна. Тухайлбал: 4 -р цэцэрлэг 612.9 сая төгрөгийн санхүүжилтээс 0.43 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн, 17-р цэцэрлэг 606.6 сая төгрөгийн санхүүжилтээс 4.7 сая төгрөг төвлөрүүлсэн байхад бага санхүүжилттэй 3-р цэцэрлэг 366.4 сая төгрөгийн санхүүжилтээс 6.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгийн 2020 оны төсвийн төсөлд цалингийн санд 10,400.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснийг 25.2 сая төгрөгөөр бууруулан 10,425.6 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 10,419.9 төгрөг зарцуулж, 5.6 сая төгрөг хэмнэсэн байна.

**Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын цалингийн сангийн тооцоо**

/ сая төгрөг/

| д/д | Байгууллага нэр | 2020 оны төсвийн төсөл | 2020 оны батлагдсан төсөв | Төлөвлөлт зөрүү | Гүйцэтгэл | Төлөвлөгөө гүйцэтгэл зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | I цэцэрлэг | 508.58 | 479.98 | 28.60 | 479.80 | 0.18 |
| **2** | II цэцэрлэг | 286.53 | 292.89 | -6.36 | 292.89 | 0.00 |
| **3** | III цэцэрлэг | 254.57 | 300.42 | -45.85 | 296.09 | 4.33 |
| **4** | IY цэцэрлэг | 669.10 | 462.46 | 206.64 | 462.45 | 0.00 |
| **5** | Y цэцэрлэг | 282.70 | 297.38 | -14.68 | 297.38 | 0.00 |
| **6** | YI цэцэрлэг | 295.06 | 298.16 | -3.10 | 298.16 | 0.00 |
| **7** | YII цэцэрлэг | 407.07 | 514.55 | -107.47 | 514.55 | 0.00 |
| **8** | YIII цэцэрлэг | 299.68 | 305.48 | -5.80 | 305.48 | 0.00 |
| **9** | IX цэцэрлэг | 266.12 | 314.54 | -48.42 | 314.54 | 0.00 |
| **10** | X цэцэрлэг | 298.55 | 309.75 | -11.20 | 309.75 | 0.00 |
| **11** | XI цэцэрлэг | 283.78 | 323.63 | -39.85 | 323.63 | 0.00 |
| **12** | XY цэцэрлэг | 481.44 | 487.90 | -6.46 | 487.90 | 0.00 |
| **13** | XYI цэцэрлэг | 313.72 | 301.70 | 12.02 | 301.70 | 0.00 |
| **14** | XYII цэцэрлэг | 465.43 | 489.37 | -23.94 | 489.35 | 0.02 |
| **15** | XYIII цэцэрлэг | 393.67 | 324.41 | 69.25 | 324.41 | 0.00 |
| **16** | XIX цэцэрлэг | 231.75 | 310.39 | -78.64 | 310.20 | 0.19 |
| **17** | XX цэцэрлэг | 428.29 | 393.57 | 34.72 | 393.57 | 0.00 |
| **18** | XXI цэцэрлэг | 491.15 | 484.53 | 6.62 | 484.53 | 0.00 |
| **19** | XXII цэцэрлэг | 452.50 | 414.90 | 37.60 | 414.90 | 0.00 |
| **20** | XXIII цэцэрлэг | 387.16 | 388.88 | -1.72 | 388.88 | 0.00 |
| **21** | XXIV цэцэрлэг | 275.35 | 329.47 | -54.12 | 329.47 | 0.00 |
| **22** | XXVI цэцэрлэг | 444.73 | 440.72 | 4.02 | 440.72 | 0.00 |
| **23** | XXVII цэцэрлэг | 329.55 | 75.25 | 254.30 | 75.23 | 0.02 |
| **24** | Дэгдээхэй цэцэрлэг | 461.92 | 448.53 | 13.39 | 448.53 | 0.00 |
| **25** | Оюу цэцэрлэг | 177.30 | 440.45 | -263.15 | 440.45 | 0.00 |
| **26** | Бялзуухай цэцэрлэг | 296.27 | 288.27 | 8.00 | 288.27 | 0.00 |
| **27** | Одод цэцэрлэг | 286.81 | 292.85 | -6.04 | 292.85 | 0.00 |
| **28** | Унага цэцэрлэг | 442.99 | 417.91 | 25.08 | 417.91 | 0.00 |
| **29** | Эрх бүжинхэн цэцэрлэг | 188.63 | 197.24 | -8.61 | 196.38 | 0.86 |
| **ДҮН** | | **10400.41** | **10425.58** | **-25.16** | **10419.97** | **5.61** |

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 29 цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс 944 албан хаагчдад 96.2 сая төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

## ОРХОН АЙМГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

| д/д | Байгууллагын нэр | Ажилтан тоо | Олгосон дүн | Нэг хүний дундаж |
|---|---|---|---|---|
| 1 | I цэцэрлэг | 39 | 4,836 | 124 |
| 2 | II цэцэрлэг | 26 | 2,212 | 85 |
| 3 | III цэцэрлэг | 23 | 2,691 | 117 |
| 4 | IY цэцэрлэг | 41 | 4,689 | 114 |
| 5 | Y цэцэрлэг | 26 | 2,358 | 91 |
| 6 | YI цэцэрлэг | 26 | 2,522 | 97 |
| 7 | YII цэцэрлэг | 43 | 4,388 | 102 |
| 8 | YIII цэцэрлэг | 25 | 2,043 | 82 |
| 9 | IX цэцэрлэг | 26 | 2,252 | 87 |
| 10 | X цэцэрлэг | 26 | 2,130 | 82 |
| 11 | XI цэцэрлэг | 41 | 3,245 | 79 |
| 12 | XY цэцэрлэг | 30 | 4,579 | 153 |
| 13 | XYI цэцэрлэг | 27 | 2,581 | 96 |
| 14 | XYII цэцэрлэг | 41 | 4,100 | 100 |
| 15 | XYIII цэцэрлэг | 35 | 3,602 | 103 |
| 16 | XIX цэцэрлэг | 26 | 2,508 | 96 |
| 17 | XX цэцэрлэг | 35 | 4,123 | 118 |
| 18 | XXI цэцэрлэг | 41 | 4,129 | 101 |
| 19 | XXII цэцэрлэг | 41 | 4,317 | 105 |
| 20 | XXIII цэцэрлэг | 38 | 3,744 | 99 |
| 21 | XXIV цэцэрлэг | 28 | 3,012 | 108 |
| 22 | XXVI цэцэрлэг | 40 | 4,313 | 108 |
| 23 | XXVII цэцэрлэг | 29 | 1,189 | 41 |
| 24 | Дэгдээхэй цэцэрлэг | 40 | 4,600 | 115 |
| 25 | Оюу цэцэрлэг | 41 | 4,358 | 106 |
| 26 | Бялзуухай цэцэрлэг | 26 | 2,927 | 113 |
| 27 | Одод цэцэрлэг | 27 | 3,166 | 117 |
| 28 | Унага цэцэрлэг | 38 | 4,104 | 108 |
| 29 | Эрх бужинхэн цэцэрлэг | 19 | 1,508 | 79 |
| | ДҮН | **944** | **96,223** | |

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлыг 1,224.8 сая төгрөг, урсгал засварын зардлыг 57.3 сая төгрөг нийт 1,282.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэлээр тогтмол зардалд 804.9 сая төгрөг, урсгал засварын зардалд 50.2 сая төгрөг, нийт 855.3 сая төгрөг зарцуулан, тогтмол зардлаас 419.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас 7.1 сая төгрөг, нийт 426.9 сая төгрөг хэмнэн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Түлш халаалтын зардлын тооцоо /сая.төг/

| Д/д | Байгууллага нэр | 2020 оны төсвийн төсөл | 2020 оны батлагдсан төсөв | Төлөвлөлт зөрүү | гүйцэтгэл | Төлөвлөгөө гүйцэтгэл зөрүү буюу хэмнэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | I цэцэрлэг | 26.85 | 20.11 | 6.74 | 15.48 | 4.63 |
| 2 | II цэцэрлэг | 11.81 | 7.94 | 3.87 | 7.94 | 0.00 |
| 3 | III цэцэрлэг | 36.96 | 32.65 | 4.31 | 32.65 | 0.00 |
| 4 | IY цэцэрлэг | 32.13 | 31.64 | 0.49 | 26.80 | 4.84 |
| 5 | Y цэцэрлэг | 16.09 | 18.83 | -2.75 | 12.37 | 6.46 |
| 6 | YI цэцэрлэг | 20.71 | 10.98 | 9.74 | 8.55 | 2.43 |
| 7 | YII цэцэрлэг | 31.88 | 33.24 | -1.37 | 33.24 | 0.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **8** | YIII цэцэрлэг | 18.69 | 17.58 | 1.11 | 15.46 | 2.12 |
| **9** | IX цэцэрлэг | 17.42 | 16.24 | 1.18 | 18.11 | -1.88 |
| **10** | X цэцэрлэг | 16.90 | 19.89 | -2.99 | 15.83 | 4.06 |
| **11** | XI цэцэрлэг | 36.00 | | 36.00 | | 0.00 |
| **12** | XY цэцэрлэг | 28.76 | 29.58 | -0.82 | 17.53 | 12.06 |
| **13** | XYI цэцэрлэг | 11.08 | 19.94 | -8.86 | 12.50 | 7.44 |
| **14** | XYII цэцэрлэг | 25.03 | 19.34 | 5.69 | 21.29 | -1.95 |
| **15** | XYIII цэцэрлэг | 18.64 | 10.95 | 7.69 | 10.92 | 0.04 |
| **16** | XIX цэцэрлэг | 17.91 | 16.71 | 1.20 | 10.45 | 6.26 |
| **17** | XX цэцэрлэг | 15.32 | 16.33 | -1.01 | 8.99 | 7.33 |
| **18** | XXI цэцэрлэг | 23.48 | 25.84 | -2.37 | 23.48 | 2.36 |
| **19** | XXII цэцэрлэг | 38.58 | 17.49 | 21.09 | 14.88 | 2.61 |
| **20** | XXIII цэцэрлэг | 30.71 | 30.71 | 0.00 | 14.93 | 15.78 |
| **21** | XXIV цэцэрлэг | 7.90 | 7.28 | 0.62 | 5.49 | 1.79 |
| **22** | XXVI цэцэрлэг | 28.97 | 29.58 | -0.62 | 9.46 | 20.13 |
| **23** | XXVII цэцэрлэг | 15.32 | | 15.32 | | 0.00 |
| **24** | Дэгдээхэй цэцэрлэг | 32.22 | 23.34 | 8.88 | 20.73 | 2.60 |
| **25** | Оюу цэцэрлэг | 25.16 | 25.93 | -0.77 | 22.05 | 3.88 |
| **26** | Бялзуухай цэцэрлэг | 19.07 | 19.98 | -0.91 | 15.76 | 4.22 |
| **27** | Одод цэцэрлэг | 17.69 | 15.74 | 1.95 | 15.85 | -0.10 |
| **28** | Унага цэцэрлэг | 53.43 | 24.99 | 28.44 | 18.44 | 6.55 |
| **29** | Эрх бүжинхэн цэцэрлэг | 9.65 | 12.21 | -2.56 | 2.66 | 9.55 |
| **30** | Ашиглалтад орох | | 56.91 | -56.91 | | 56.91 |
| ДҮН | | **684.35** | **611.97** | **72.37** | **431.85** | **180.12** |

Сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгүүдийн түлш халаалтын зардлыг цэцэрлэгүүд төсвийн төсөлдөө 681.4 сая төгрөгөөр санал ирүүлснийг аймгийн ИТХ-аар 72.4 сая төгрөгөөр бууруулан 611.9 сая төгрөгөөр баталсан, гүйцэтгэлээр 431.8 сая төгрөг зарцуулж, 180.2 сая төгрөг хэмнэсэн нь гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал Ковид 19 цар тахлаас шалтгаалж сургууль, цэцэрлэг хичээллэхээ болиход зардал багассан ч ихэнх нь бодит бус төлөвлөснөөс үүссэн хэмнэлт байна.

Иймд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн саналыг ИТХ-д оруулж батлуулахдаа өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж бодитой санал оруулан батлуулж байх шаардлагатай байна.

**2.3.2 ЕБС-ийн салбарын тогтмол зардлыг орон нутгаас олгохдоо бодитой төлөвлөөгүйгээс 101.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн, цалингийн хэмнэлтээс урамшуулалд 243.5 сая төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Орхон аймгийн ИТХ-ын 2019 оны 11-р сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн тусгай шилжүүлгийн санхүүжилтийг 23,747.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 1,352.8 сая төгрөг, нийт 25,354.7 сая төгрөгөөр баталсан, ИТХ-ын ээлжит бус хуралдааны 2020 оны 09-р сарын 07-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн тусгай шилжүүлгийн санхүүжилтийг 23,575.8

сая төгрөг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 1,352.2 сая төгрөг, нийт 25,181.9 сая төгрөг болгон 172.8 сая төгрөгөөр бууруулан баталсан.

ЕБС-ийн тогтмол зардлыг орон нутгаас санхүүжүүлэх дүнг 1,352.8 сая төгрөгөөр баталсан ч санхүүжилтийн эрхийг 1,320.6 сая төгрөгөөр буюу 32.2 сая төгрөгөөр бууруулж нээсэн нь ашиглалтад орох 2 сургууль, 2 цэцэрлэгийн гүйцэтгэл гараагүйтэй холбоотой байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11-р сарын 13-ны өдрийн 1а/2788 дугаартай албан бичгийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны 11-р сарын 30-ний өдрийн 02/04 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн тусгай шилжүүлгийн нийт санхүүжилтийг 100.0 сая төгрөгөөр бууруулан 25,081.9 сая төгрөгөөр баталжээ.

Ерөнхий боловсролын 17 сургууль болон албан бус насан туршийн боловсрол олгох төвд бага бүлэгт 10370, дунд бүлэгт 6171, ахлах бүлэгт 3179 нийт 19720 хүүхэд хамруулан сургалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн гүйцэтгэлээр бага бүлэгт 10609, дунд бүлэгт 6640, ахлах бүлэгт 3068, нийт 120317 хүүхэд хамруулахаар төлөвлөснөөс 597 хүүхэд илүү хамруулсан байна.

Ерөнхий боловсролын 17 сургууль болон албан бус насан туршийн боловсрол олгох төвд нийт 975 багш, бусад ажилтан 522 нийт 1497 багш ажилчид ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 991 багш, бусад ажилтан 502, нийт 1493 багш ажилчид ажилласан байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулсан ерөнхий боловсролын 17 сургууль орон нутгийн төсвөөс 1,320.6 сая төгрөгийн санхүүжилт авахаар эрх нээж, гүйцэтгэлээр 1,019.8 сая төгрөг зарцуулан, орон нутгийн төсөвт 300.8 сая төгрөг, тусгай шилжүүлгийн санхүүжилтээр 23,709.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэлээр 23,527.1 сая төгрөг зарцуулан 182.9 сая төгрөг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Ерөнхий боловсролын сургуулиудын санхүүжилтийн тооцоо /сая.төг/

| д/д | Байгууллагын нэр | ОН-ийн санхүүжилт | Орон нутагт төвлөрүүлсэн | Цэвэр санхүүжилт | ТЗШ-ийн санхүүжилт | Улсын төсөвт төвлөрүүлсэн | Цэвэр санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 дүгээр сургууль | 110.23 | 12.43 | 97.80 | 2,439.10 | 14.65 | 2,424.45 |
| 2 | 2 дугаар сургууль | 46.54 | 10.21 | 36.33 | 781.39 | 8.34 | 773.05 |
| 3 | 3 дугаар сургууль | 69.11 | 24.65 | 44.46 | 1,426.38 | 1.62 | 1,424.76 |
| 4 | 4 дүгээр сургууль | 109.64 | 12.73 | 96.90 | 2,906.09 | 12.35 | 2,893.74 |
| 5 | 5 дугаар сургууль | 78.69 | 20.45 | 58.24 | 2,005.50 | 12.36 | 1,993.14 |
| 6 | 7 дугаар сургууль | 47.11 | 7.66 | 39.45 | 1,004.77 | 9.63 | 995.13 |
| 7 | 8 дугаар сургууль | 85.36 | 19.01 | 66.35 | 1,440.98 | 8.60 | 1,432.38 |
| 8 | 13 дугаар сургууль | 75.70 | 13.00 | 62.70 | 1,757.11 | 1.96 | 1,755.16 |
| 9 | 14 дүгээр сургууль | 82.47 | 12.22 | 70.25 | 2,191.90 | 43.03 | 2,148.87 |
| 10 | 15 дугаар сургууль | 110.70 | 69.37 | 41.33 | 1,188.17 | 17.94 | 1,170.23 |
| 11 | 16 дугаар сургууль | 40.14 | 9.99 | 30.15 | 879.37 | 11.31 | 868.06 |
| 12 | 17 дугаар сургууль | 67.89 | 11.37 | 56.53 | 1,151.15 | 8.39 | 1,142.76 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **13** | 18 дугаар сургууль | 40.14 | 9.99 | 30.15 | 879.37 | 11.31 | 868.06 |
| **14** | 20 дугаар сургууль | 135.97 | 39.97 | 96.01 | 1,062.90 | 1.22 | 1,061.68 |
| **15** | Ирээдүйн одод сургууль | 20.41 | 1.70 | 18.71 | 591.06 | 13.12 | 577.94 |
| **16** | Жаргалантын дунд сургууль | 167.85 | 24.52 | 143.33 | 899.50 | 3.14 | 896.36 |
| **17** | Хувийн сургуулиуд | - | - | - | 842.39 | 3.81 | 838.57 |
| **18** | Албан бус насан туршийн боловсрол олгох төв | 32.68 | 1.56 | 31.12 | 262.85 | 0.15 | 262.70 |
| ДҮН | | **1320.62** | **300.82** | **1019.79** | **23709.97** | **182.92** | **23527.05** |

Дээрхээс үзэхэд сургуулиудын буцаан төвлөрүүлсэн санхүүжилт нь харилцан адилгүй байна. Тухайлбал: 4-р сургууль 2,906.9 сая төгрөгийн санхүүжилтээс 12.35 сая төгрөгийг төвлөрүүлсэн, 14-р сургууль 2,191.0 сая төгрөгийн санхүүжилтээс 43.03 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Харин санхүүжилт багатай 18-р сургууль 879.37 сая төгрөгийн санхүүжилтээс 11.31 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Ерөнхий боловсролын 17 сургуулийн цалингийн санд 19,182.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр 19,169.1 сая төгрөг зарцуулан, 13.7 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын цалингийн сангийн тооцоо /сая.төг/

| д/д | Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт |
|---|---|---|---|---|
| **1** | 1 дүгээр сургууль | 2043.65 | 2042.58 | 1.08 |
| **2** | 2 дугаар сургууль | 665.98 | 660.91 | 5.07 |
| **3** | 3 дугаар сургууль | 1216.79 | 1216.78 | 0.00 |
| **4** | 4 дүгээр сургууль | 2445.10 | 2444.73 | 0.37 |
| **5** | 5 дугаар сургууль | 1670.53 | 1670.53 | 0.00 |
| **6** | 7 дугаар сургууль | 842.10 | 841.85 | 0.25 |
| **7** | 8 дугаар сургууль | 1224.99 | 1218.86 | 6.13 |
| **8** | 13 дугаар сургууль | 1491.17 | 1491.17 | 0.00 |
| **9** | 14 дүгээр сургууль | 1852.09 | 1851.57 | 0.52 |
| **10** | 15 дугаар сургууль | 997.71 | 997.53 | 0.19 |
| **11** | 16 дугаар сургууль | 749.32 | 749.28 | 0.04 |
| **12** | 17 дугаар сургууль | 972.20 | 972.20 | 0.00 |
| **13** | 18 дугаар сургууль | 648.76 | 648.76 | 0.00 |
| **14** | 20 дугаар сургууль | 891.53 | 891.53 | 0.00 |
| **15** | Ирээдүйн одод сургууль | 494.33 | 494.30 | 0.04 |
| **16** | Жаргалантын дунд сургууль | 747.65 | 747.65 | 0.00 |
| **17** | Албан бус насан туршийн боловсрол олгох төв | 228.88 | 228.88 | 0.00 |
| **ДҮН** | | 19182.80 | 19169.12 | 13.68 |

Ерөнхий боловсролын сургуулиуд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 17 сургуулийн захирлын тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс 1,475

албан хаагчдад 243.6 сая төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэн.

Урамшуулал олгосон тооцоо /сая.төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Ажилтан тоо | Олгосон дүн | Нэг хүнд олгосон дундаж |
|---|---|---|---|---|
| **1** | 1 дүгээр сургууль | 152 | 25,855.2 | 170.1 |
| **2** | 2 дугаар сургууль | 54 | 8,265.9 | 153.1 |
| **3** | 3 дугаар сургууль | 94 | 16,703.0 | 177.7 |
| **4** | 4 дүгээр сургууль | 182 | 30,430.4 | 167.2 |
| **5** | 5 дугаар сургууль | 124 | 20,825.4 | 167.9 |
| **6** | 7 дугаар сургууль | 70 | 10,500.0 | 150.0 |
| **7** | 8 дугаар сургууль | 81 | 13,284.0 | 164.0 |
| **8** | 13 дугаар сургууль | 109 | 16,949.5 | 155.5 |
| **9** | 14 дүгээр сургууль | 134 | 21,556.2 | 160.9 |
| **10** | 15 дугаар сургууль | 86 | 14,431.0 | 167.8 |
| **11** | 16 дугаар сургууль | 62 | 9,362.0 | 151.0 |
| **12** | 17 дугаар сургууль | 85 | 13,343.0 | 157.0 |
| **13** | 18 дугаар сургууль | 52 | 7,873.8 | 151.4 |
| **14** | 20 дугаар сургууль | 79 | 15,247.0 | 193.0 |
| **15** | Ирээдүйн одод сургууль | 37 | 6,560.1 | 177.3 |
| **16** | Жаргалантын дунд сургууль | 57 | 10,032.0 | 176.0 |
| **17** | Албан бус насан туршийн боловсрол олгох төв | 17 | 2,320.5 | 136.5 |
| ДҮН | | **1475** | **243,539.1** | **165.1** |

Дээрх олгосон урамшуулал нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Сургууль, цэцэрлэгийн байгууллагуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна цэцэрлэгийн эрхлэгч болон сургуулийн захирлын тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс 2,419 алба хаагчдад 339.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан тул төсвийн шууд захирагч нарт санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулиудын орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлыг 1,256.5 сая төгрөг, урсгал засварын зардлыг 263.6 сая төгрөг, нийт 1,520.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр тогтмол зардалд 989.2 сая төгрөг, урсгал засварын зардалд 28.3 сая төгрөг нийт 1,017.5 сая төгрөгийг зарцуулан, тогтмол зардлаас 26,763.0 сая төгрөг, урсгал засварын зардлаас 23,563.0 сая төгрөг, нийт 502.6 сая төгрөг хэмнэн, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Түлш, халаалтын зардлын тооцоо /сая.төгрөг/

| Д/д | Байгууллага нэр | 2020 оны байгууллагын ирүүлсэн төсвийн төсөл | 2020 оны батлагдсан төсөв | Төлөвлөлт зөрүү | Гүйцэтгэл | Төлөвлөгөө гүйцэтгэл зөрүү буюу хэмнэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 дүгээр сургууль | 137.78 | 74.67 | 63.11 | 71.58 | 3.09 |
| 2 | 2 дугаар сургууль | 31.47 | 27.27 | 4.21 | 20.25 | 7.02 |
| 3 | 3 дугаар сургууль | 47.75 | 34.72 | 13.03 | 28.57 | 6.15 |
| 4 | 4 дүгээр сургууль | 74.67 | 58.55 | 16.12 | 53.69 | 4.85 |
| 5 | 5 дугаар сургууль | 40.21 | 32.14 | 8.07 | 30.55 | 1.59 |
| 6 | 7 дугаар сургууль | 31.59 | 30.45 | 1.13 | 26.34 | 4.11 |
| 7 | 8 дугаар сургууль | 57.95 | 54.51 | 3.44 | 45.91 | 8.60 |
| 8 | 13 дугаар сургууль | 62.79 | 38.08 | 24.71 | 31.75 | 6.33 |
| 9 | 14 дүгээр сургууль | 85.24 | 44.85 | 40.38 | 34.63 | 10.22 |
| 10 | 15 дугаар сургууль | 97.53 | 45.73 | 51.80 | 22.63 | 23.10 |
| 11 | 16 дугаар сургууль | 76.03 | 25.46 | 50.57 | 18.16 | 7.30 |
| 12 | 17 дугаар сургууль | 58.13 | 27.54 | 30.59 | 27.54 | - |
| 13 | 18 дугаар сургууль | 24.26 | 21.29 | 2.97 | 21.05 | 0.24 |
| 14 | 20 дугаар сургууль | 86.99 | 60.86 | 26.13 | 45.05 | 15.81 |
| 15 | Ирээдүйн одод сургууль | 22.05 | 9.81 | 12.24 | 10.90 | -1.09 |
| 16 | Жаргалантын дунд сургууль | 148.84 | 137.85 | 10.98 | 134.07 | 3.78 |
| | **ДҮН** | **1,083.28** | **723.79** | **359.50** | **622.68** | **101.10** |

Ерөнхий боловсролын сургуулиудын түлш халаалтын зардлыг төсвийн төсөлдөө 1,083.3 сая төгрөгөөр санал ирүүлснийг аймгийн ИТХ-аар 359.5 сая төгрөгөөр бууруулж 723.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 622.7 сая төгрөг зарцуулан, 101.1 сая төгрөг хэмнэсэн нь төсвийг бодиттой төлөвлөөгүйгээс үүссэн хэмнэлт байна.

Орхон аймгийн хэмжээнд тусгай шилжүүлгийн СӨБ, ЕБС-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа сургууль цэцэрлэгүүд төсвийн төсөл боловсруулж аймгийн БСУГ-т ирүүлсэн боловч төсвийн төслийн баримт бичигт төсвийн танилцуулга, хууль эрх зүйн шийдвэр тогтоолын хуулбар, төсвийн төслийн үнэн зөвийг нотлох баримт бичгүүдийг нийтлэг бүрдүүлээгүй, төсвийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг хангахгүйгээр төсөв боловсруулж байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 3. Ковид цар тахлаас шалтгаалан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 35 төсөл арга хэмжээ бүрэн дуусаагүй он дамжин хэрэгжиж байна.**

**3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.8 хувийн биелэлттэй байна.**

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2020 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 51.8 тэрбум төгрөгийн 415 төсөл арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

- Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 47.9 тэрбум төгрөгийн 265 худалдан авах ажиллагаа тусгагдсанаас аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39.5 тэрбум төгрөгийн 256 ажил, улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 8.3 тэрбум төгрөгийн 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс харьяа байгууллагуудад 9 ажлын худалдан авах ажиллагааны эрхийг /*Цагдаагийн газарт-3, тагнуулын газарт-1, Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-2, Баян-өндөр ЗДТГ-1, Жаргалант сум ЗДТГ-2*/ шилжүүлсэн байна.

- Баян-Өндөр сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 901.2 сая төгрөгийн 51 төсөл арга хэмжээ.
- Жаргалант сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 872.1 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээ.
- Хот тохижуулах газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 843.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ.

**Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт**

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 415 төсөл арга хэмжээний худалдан авалтаас 2 хасагдаж нийт 413 төсөл арга хэмжээ тусгагдсан ба төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

- Шалгарч гэрээ байгуулсан-404
- Амжилтгүй болсон-2
- Зураг төсөв ирээгүй-4
- Техникийн тодорхойлолт хүлээгдэж буй-3 худалдан авалт байна.

Нийт 413 худалдан авалтын төлөвлөгөөнөөс шалгарч гэрээ байгуулсан 97.8 хувь 404 төсөл арга хэмжээ, тендер зарлаад амжилтгүй болсон 0.5 хувь буюу 2 төсөл арга хэмжээ, техникийн тодорхойлолт, зураг төсөв хүлээгдэж буй 1.7 хувь буюу 7 төсөл арга хэмжээ байна.

**Эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааны биелэлт**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр 2020 онд 8.3 тэрбум төгрөгийн 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан. Үүнд:

- ❖ Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 4.1 тэрбум төгрөгийн 2 ажил
- ❖ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2.0 тэрбум төгрөгийн 2 ажил
- ❖ Боловсрол шинжлэх ухааны яамнаас 2.1 тэрбум төгрөгийн 5 ажил

Эрх шилжиж ирсэн 9 ажлаас гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан-8, тендер зарлаад амжилтгүй болсон боловч хөрөнгө татагдсан 1 ажил байна.

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа биелснээр харагдаж байгаа боловч санхүүжилтийн зарлагын мэдээгээр хэмнэлттэй байгаа нь худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгч шалгарсан ч цар тахалтай холбоотойгоор төсөл арга хэмжээ бүрэн дуусаж санхүүжилт гараагүйтэй холбоотой байна.

**3.2. 2020 онд ОНХС-аас олгох аймаг, сумын орлогын шилжүүлгийг 4,744.2 сая төгрөгөөр баталсан байна.**

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 4,295.9 сая төгрөгөөр баталснаас аймагт 2,427.6 сая төгрөг, Жаргалант суманд 995.1 сая төгрөг, Баян-өндөр суманд 873.2 сая төгрөг хуваарилахаар аймгийн ИТХ-ын 15/03 дугаар тогтоолд тусгагджээ.

**<u>Аймгийн ОНХС:</u>**

Аймгийн хэмжээнд ОНХС-ын эх үүсвэрийг 2,427.6 сая төгрөг, өмнөх оны шилжих үлдэгдэл 749.5 сая төгрөг нийт 3,177.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 27 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 15 төсөл арга хэмжээ бүрэн дуусаж, 12 төсөл арга хэмжээ он дамжсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2,138.2 сая төгрөгийг шинэ хөрөнгө оруулалтын ажилд, өмнөх оны 749.5 сая төгрөгийн шилжих үлдэгдлээс шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын

636.8 сая төгрөг нийт 2,775.0 сая төгрөг зарцуулахаас 2,096 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 679.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Баян-Өндөр сумын ОНХС:**

Тайлант онд 873.1 сая төгрөгийн санхүүжилт авч, 54 төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр, сумын ИТХ-аар баталсан.

Худалдан авах ажиллагааны 2 төсөл арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалтаар, 2 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцооны аргаар, 25 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 22 төсөл арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар тус тус зохион байгуулсан байна.

Оны эцэст 632.1 сая төгрөгийг зарцуулж, 43 төсөл арга хэмжээ бүрэн дууссан бол 11 төсөл арга хэмжээ он дамжин гүйцэтгэгдэхээр болсон байна.

**Жаргалант сумын ОНХС:**

Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сан тайлант онд аймгаас 995.0 сая төгрөгийн санхүүжилт, өмнөх оны үлдэгдэл 192.6 сая төгрөг, орон нутгийн ерөнхий орлогоос 152.2 сая төгрөг нийт 1,339.9 сая төгрөгөөр 47 төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд гүйцэтгэх 47 төсөл арга хэмжээний 4 төсөл арга хэмжээ нь шууд худалдан авалтын аргаар, 36 төсөл арга хэмжээ нь харьцуулалтын аргаар зохион байгуулсан.

Оны эцэст 1,166.4 сая төгрөгийг зарцуулж, 35 төсөл арга хэмжээ бүрэн дууссан бол 12 төсөл арга хэмжээ он дамжин гүйцэтгэгдэхээр болсон байна.

**3.3 2019 онтой харьцуулахад нэмэлт төсвийн гүйцэтгэлийн зардал 1,337.0 сая төгрөгөөр өссөн байна.**

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд 2020 онд 6,425.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, 6,151.6 сая төгрөгийг зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 263.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 10.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад зардал 1,337.0 сая төгрөгөөр өссөн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг графикаар харуулбал: *(сая.төгрөг)*




**Хандив тусламжийн орлого**: Хандиваар 21.7 сая төгрөгийн орлого орсон нь боловсролын салбарын байгууллагын /4-р сургууль/ эцэг эхийн хандивын орлогоос бүрдсэн байна.

**ЗГНХ, ЗДНХ, ангилагдаагүй бусад** орлогод нийт 2,645.0 сая төгрөгийн орлого орсноос 3,974.4 сая төгрөг нь боловсролын байгууллагын, 2,621.1 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын орлого байна. Үүнээс 1,254.4 сая төгрөг нь байгаль хамгаалах арга хэмжээний санхүүжилт, 343.2 сая төгрөг нь ахмад, хүүхдийн автобусны санхүүжилтэд

зарцуулагдсан байна. Орон нутгаас олгосон нэмэлт санхүүжилтийг төсвийн 17 байгууллага, төсөл сангийн тайлан дээр байгууллага хоорондын тооцоо үүсгэж, давхардсан ажил гүйлгээний дүнгээр нийт 2,401.1 сая төгрөгийн устгах бичилт хийсэн. Мөн 220.0 сая төгрөгийн ажил гүйлгээг Улсын төсвийн байгууллага буюу ЗГ-ын нөөц сантай хоорондын тооцоо тус тус үүсгэсэн байна.

Орон нутгаас олгосон нэмэлт санхүүжилтийн 1,254.4 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах цэцэрлэгжүүлэх арга хэмжээний зардалд, 205.4 сая төгрөгийг биеийн тамир спорт, соёл үйлчилгээний арга хэмжээний зардалд, 368.2 сая төгрөгийг хотын тохижилт үйлчилгээ, ахмад, хүүхдийн нийтийн тээврийн хөнгөлөлт зэрэг бусад нийтлэг ерөнхий үйлчилгээний зардалд тус тус зарцуулагдсан байна.

**<u>Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлого:</u>** Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан нийт 21 байгууллагад 1,730.7 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн, үүнээс орон нутгийн төсвийн байгууллагын орлого 1,558.6 сая төгрөг, боловсролын салбарын байгууллагуудын орлого 50.7 сая төгрөг, эрүүл мэндийн байгууллагад 14.9 сая төгрөг, 106.3 сая төгрөг нь ГБХЗХГ-ын Залуучууд хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилт байна.

Дээрх ажил гүйлгээг төсвийн байгууллагууд хоорондын тооцоо үүсгэж баталгаажуулж орон нутгийн нэгтгэсэн тайланд 646.4 сая төгрөгийн ажил гүйлгээнд устгах бичилт хийгдэж, 1,084.2 сая төгрөгийн ажил гүйлгээг бусад ТЕЗ болон харьяа яам агентлагуудтай тооцоо үүсгэсэн байна.

**<u>Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</u>**

Нийт 2,048.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 1,851.1 сая төгрөг нь түрээсийн орон сууцны төлбөр бөгөөд Өмчийн харилцааны газрын нэмэлт дансаар дамжуулан Хөгжлийн банканд төвлөрүүлсэн төлбөр, 35.8 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулиудын түрээсийн сурах бичгийн үнийг нэмэлт дансаар дамжуулан Боловсрол шинжлэх ухааны яаманд төвлөрүүлсэн орлого, 161.2 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудаас бүрдүүлсэн орлого байна.

Нэмэлт санхүүжилтийн зарлагыг графикаар харуулбал: *(сая.төгрөг)*




Нийт зарцуулалтыг зардлын нэр төрлөөр харуулбал:

| | |
|---|---|
| 1. Цалин хөлс, НДШ-ийн зардал | 512.7 сая төгрөг |
| 2. Байр ашиглалтын зардал | 107.0 сая төгрөг |
| 3. Хангамж, бараа материалын зардал | 228.0 сая төгрөг |
| 4. Норматив зардал | 42.8 сая төгрөг |
| 5. Урсгал засвар, эд хогшлын зардал | 209.7 сая төгрөг |
| 6. Томилолтын зардал | 19.4 сая төгрөг |
| 7. Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХ | 2,128.7 сая төгрөг |

8. Бараа үйлчилгээний бусад зардал 1,922.0 сая төгрөг
9. Тэтгэмж урамшууллын зардал 888.1 сая төгрөг
10. Хөрөнгийн зардал 92.8 сая төгрөг нийт 6,151.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 8 байгууллагад 173.9 сая төгрөгийн авлага үүсгэж, орон нутгаас буцаан олгохоор тооцоо нийлсэн байна. Үүнд:

- Байгаль орчны газар-91.7 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ-23.5 сая төгрөг
- Баян-өндөр сумын ЗДТГ-4.5 сая төгрөг
- 4-р сургууль-0.91 сая төгрөг
- Биеийн тамир спортын газар-13.1 сая төгрөг
- Жаргалант эмнэлэг-3.5 сая төгрөг
- Жаргалант сургууль-11.2 сая төгрөг

***АУДИТЫН ДҮГНЭЛТ:***

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сангийн яамнаас хянасан орлого зарлагын дүнгээс орлогыг 8,650.2 сая төгрөг, зарлагыг 3,157.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж орон нутгийн төсвийг баталжээ.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Эрдэнэт сангийн төсөв батлахдаа ОНӨҮГ-т санхүүжилт олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зүйл заалттай нийцэхгүй байна.
- Жаргалант сумын өмнөх оны ерөнхий дансны үлдэгдлийг энэ онд ОНХС-г санхүүжүүлэхээр эх үүсвэр талд баталсан нь Төсвийн тухай хуулийн 60.2 заалтыг зөрчсөн байна.
- Газрын төлбөрийн орлого 2,710.0 сая төгрөг, хог хаягдлын хураамж 22.8 сая төгрөгөөр тасарсан байна.
- Төсвийн зардлын хэмнэлт нь ковид 19 цар тахалтай холбоотойгоор Сангийн яамнаас зарим зардалд хязгаарлалт хийснээс шалтгаалж төсвийн гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна.
- Тусгай шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг бодитой төлөвлөөгүйгээс 281.2 сая төгрөгийн хэмнэлт үүсч, цалингийн зардлын хэмнэлтээс 339.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.8 хувийн биелэлттэй байна.
- 2020 онд ОНХС-аас олгох аймаг, сумын орлогын шилжүүлгийг 4,744.2 сая төгрөгөөр баталсан байна.
- 2019 онтой харьцуулахад нэмэлт төсвийн гүйцэтгэлийн зардал 1,337.0 сая төгрөгөөр өссөн байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч С.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Бямбацэцэг нарт:

ОРХОН АЙМГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1. Орон нутгийн байгууллагуудын хэвлэл мэдээллийн зардлыг зүй зохистой арвилан хэмнэлттэй байхаар зарцуулахад хяналт тавьж, мэдээлэх мэдээлэл давхардаж буй эсэхийг хэвлэл мэдээллийн ажилтнууд бүрэн хянаж баталгаажуулсны дараа санхүүжилтийг олгож байх
2. Тусгай шилжүүлгийн тогтмол зардлын төсвийн саналыг харгалзан төсвийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж бодитой төлөвлөж байх.
3. ОНӨҮГ-ын санхүүжилтийг өөрөө өөрийгөө санхүүжих зарчмаар явуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах.

**Жаргалант сумын Засаг дарга, ИТХ-д**

1. Жаргалант сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлагнаж, аудитад хамруулж байх.
2. Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдлээс дараа онд ОНХС-ийн эх үүсвэрийг батлахгүй байх.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР Т.БОЛОРМАА

АУДИТОР О.ГАНТУЯА